



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**

**Нийцлийн аудитын тайлан**

**2023 оны 8  
дугаар сар**

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ НӨХӨН  
БОЛОН ДАХИН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ,  
НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ  
ХЯНАЖ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

АГУУЛГА

<b>АГУУЛГА</b> .....	<b>2</b>
<b>Товчилсон үгийн тайлбар</b> .....	<b>3</b>
<b>Хүснэгтийн товъёг</b> .....	<b>4</b>
<b>Хавсралтын товъёг:</b> .....	<b>4</b>
<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> .....	<b>5-6</b>
<b>Нэг.Ерөнхий мэдээлэл</b> .....	
<i>Error! Bookmark not defined.</i>	
<b>Хоёр. Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны орлого, зардлын талаар</b> .....	<b>9</b>
<b>Гурав. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын талаар</b> .....	<b>10</b>
<b>Дөрөв. Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт</b> .....	<b>11</b>
<b>Тав. Аудитын дүгнэлт</b> .....	<b>11</b>
<b>Зургаа. Зөвлөмж</b> .....	<b>12</b>
<b>Хавсралт</b> .....	<b>14-17</b>





## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/22 дугаар тушаалын хавсралтаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу хийж гүйцэтгэв.
<b>Аудитын зорилт</b>	Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд Баян-Өлгий аймгийн Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	Аудитад Баян-Өлгий аймгийн Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж нийтэд мэдээлэхтэй холбоотой ажлын болон санхүүгийн тайлан, баримт материалд үндэслэн холбогдох нэр дэвшигч болон байгууллагуудыг хамруулан аудитыг гүйцэтгэв.
<b>Аудитын хязгаарлалт</b>	Байхгүй
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглав.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек хэрэгжүүлж, аудитыг аудитор С.Нурлан хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2023 оны 7 дугаар сарын 19-ны өдрөөс эхлүүлж, гүйцэтгэх шатны ажлыг 8 дугаар сарын 01-ны өдрөөс 8 дугаар сарын 17-ны өдрүүдэд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 8 дугаар сарын 18-ны өдрөөс эхлүүлж, дарга тэргүүлэх аудиторын тушаалаар батлуулж, олон нийтэд мэдээлэх.

**Хүндрэл бэрхшээл**

Байхгүй.

### Нэг.Ерөнхий мэдээлэл

Баян-Өлгий аймгийн Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуулиар Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгууль 2023 оны 6 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 142 дугаар тогтоолоор Аймгийн Сонгуулийн хороог байгуулсан байна.

Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолоор Сумын Сонгуулийн хороог байгуулжээ.

Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд Монгол Ардын намаас 1, Ардчилсан намаас 1 хүн тус тус нэр дэвшсэн байна. Сонгуульд оролцсон нам, эвсэл болон тойрог, нэр дэвшигчийн тоо мэдээллийг хүснэгтээр харуулав.

#### Хүснэгт №1 Сонгуульд оролцсон нам, нэр дэвшигч, нэр дэвшсэн тойргийн талаарх судалгаа

д/д	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигч	Нэр дэвшсэн тойрог
1	Буянт сумын Монгол Ардын нам	1	Буянт сум 4-р тойрог
2	Буянт сумын Ардчилсан нам	1	Буянт сум 4-р тойрог

Эх сурвалж: Аудитын газрын судалгаа

#### Хүснэгт №2 Нам, эвсэл болон тойрог, нэр дэвшигчийн тоо мэдээлэл

Д/Д	НАМ, ЭВСЛИЙН НЭР	НАМ	ЭВСЭЛ	ТОЙРГИЙН ТОО	НЭР ДЭВШИГЧИД
1	Сумын МАН	1		1	1
2	Сумын АН	1		1	1
3	Эвсэл			0	0
4	Бие даан нэр дэвшигч			0	0
	<b>НИЙТ</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>2</b>

Эх сурвалж: Аудитын газрын судалгаа

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчидийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нам болон нэр

дэвшигчийн Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн тайлан дараах байдалтай байна. Үүнд:

**Хүснэгт №3 Нам болон нэр дэвшигчийн ирүүлсэн тайлан**

Д / Д	Сумын нэр	Намын зардлын тайланд		Үүнээс аудиторын хянасан тайлан	Нэр дэвшигчийн зардлын тайланд				Үүнээс аудиторын хянасан тайлан	Сонгуулийн зардлын тайлангаас	
		Дүгнэлт гаргуулсан	Дүгнэлт гаргуулаагүй		Харьяалах нам	Мандатын тоо	Зардлын тайланд			Дансаа бүртгүүлсэн	Дансаа бүртгүүлээгүй
							Дүгнэлт гаргуулсан	Дүгнэлт гаргуулаагүй			
1	Сумын Монгол ардын нам	1		1	МАН	1	1		1		
2	Сумын Ардчилсан нам	1		1	АН	1	1		1		
<b>НИЙТ ДҮН</b>		<b>2</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0</b>

Эх сурвалж: Аудитын газрын судалгаа

Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон Буянт сумын Монгол Ардын нам болон Ардчилсан нам нь сонгуулийн зардлын тайландаа орлого, зарлага “0” дүнтэй “Х” тайлан гаргаж “Өлгий аудит” ХХК-аар дүгнэлт гаргуулж, хуулийн хугацаанд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд сумын Монгол Ардын нам, Ардчилсан намаас нэр дэвшиж оролцсон 2 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайландаа “Өлгий аудит” ХХК-аар аудитын дүгнэлт гаргуулж, хуулийн хугацаанд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд Монгол Ардын намаас нэр дэвшсэн иргэн хандивийн хөрөнгийг өөрийн хувийн хадгаламжийн дансаар дамжуулан сонгуулийн зардлын тайландаа орлого, зарлага тайлагнаж ирүүлсэн ба Ардчилсан намаас нэр дэвшигч иргэн сонгуулийн зардлын тайландаа орлого, зарлага “0” дүнтэй “Х” тайлан ирүүлсэн байна.

“Өлгий аудит” ХХК нь Буянт сумын Монгол Ардын нам, Ардчилсан нам болон 2 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Буянт сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшсэн 2 нэр дэвшигч Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын дансыг нээлгээгүй, мөн 50.3-т “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад

мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу аймаг дахь Төрийн аудитын газарт дансаа бүртгүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчидийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу нам, эвсэл, нэр дэвшигчдэд олгосон хандивын судлагааг дэлгэрэнгүй байдлаар нэгтгэж жагсаалтыг гаргасан ба нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд бүртгэгдээгүй байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчидийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу аймгийн ХААН, Голомт, Хас, Төрийн банкны салбараас нэр дэвшигчид сонгуулийн данс нээлгээгүй гэсэн албан бичиг ирүүлсэн байна.

#### **Хоёр. Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны орлого, зардлын талаар**

Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон Монгол Ардын намаас нэр дэвшсэн иргэний сонгуулийн зардлын дансны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2.2 мянган төгрөг байсан ба 2,040.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч, сонгуулийн үйл ажиллагаанд дансаар 1,691,3 мянган төгрөгийг зарцуулан, 350.9 мянган төгрөгийг бэлнээр авч сонгуулийн зардалд зарцуулж 5.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой төлөгдөөгүй өр төлбөргүй гэж тайлагнаж ирүүлжээ.

Монгол Ардын намаас нэр дэвшсэн, нэр дэвшигчийн дансны нийт орлого нь 3,590.0 мянган төгрөг байна. Орлого нь өөрийн хөрөнгө болон иргэдээс өгсөн хандивын орлогоос бүрдсэн. Үүнд:

#### *Хүснэгт №4 Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын орлогын судалгаа*

Орлогын төрөл/нам, эвсэл бие даан нэр дэвшигчийн нэр	Нийт орлогын дүн	Орлого /мянган төгрөг/					
		Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Иргэдээс өгсөн мөнгөн хандив	Иргэний өгсөн мөнгөн бус хандив дүн	Хуулийн этгээдийн өгсөн мөнгөн хандив дүн	Хуулийн этгээдийн өгсөн мөнгөн бус хандив дүн
Монгол Ардын нам	3,590.00	0	1,550.00	2,040.00	0	0	0
Ардчилсан нам	0	0	0	0	0	0	0
<b>Нийт дүн</b>	<b>3,590.00</b>	<b>0</b>	<b>1,550.00</b>	<b>2,040.00</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Эх сурвалж: Аудитын газрын судалгаа

Монгол Ардын намаас нэр дэвшигч сонгуулийн зардалд нийт 3,590.0 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараахад 450.0 мянган төгрөг, намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал 150.0 мянган төгрөг, сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийхэд 180.0 мянган төгрөг, бусад зардал 2,804.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад зардалд зарцуулсан сонгуулийн зардал нь ухуулах байрны түрээсийн зардалд 100.0 мянган төгрөг, нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардалд 1,560.0 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн зардалд 500.0 мянган төгрөг, сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардалд 644.3 мянган төгрөг нийтдээ 2,804.3 мянган төгрөгийг зарцуулсан гэж тайлагнасан байна. Үүнд:

*Хүснэгт №5 Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын судалгаа*

<b>ЗАРДЛЫН АНГИЛАЛ</b>	<b>МӨНГӨН ДҮН /Мянган төгрөг/</b>
<b>2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,584.30</b>
<b>2.1 Сонгуулийн зардал</b>	<b>780.0</b>
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	450.0
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	0
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	150.0
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	180.0
2.1.5. сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	0.0
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	0.0
2.1.7 цахим орчин ашиглах зардал	0.0
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	0.0
<b>2.2 Бусад зардлын дүн</b>	<b>2804.3</b>

Эх сурвалж: Аудитын газрын судалгаа

**Гурав. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын талаар**

Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон Монгол Ардын намаас нэр дэвшсэн иргэнд 27 иргэн хандив өргөсөн байна.

Аудитаар хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандив хүлээн авсан, зарцуулсан зөрчил дутагдал илрээгүй болно.

## **Дөрөв. Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт**

Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон Монгол Ардын намаас нэр дэвшсэн иргэний сонгуулийн зардлын тайланг хянасан аудитаар дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:

- “Өлгий аудит” ХХК нь нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргахдаа сонгуулийн зардлын данс нээлгээгүй, батлагдсан маягтын дагуу сонгуульд ямар ч орлого төвлөрүүлж, зардал гаргаагүй тайлан гаргаж ирүүлсэн нам, нэр дэвшигчдэд зөрчилгүй дүгнэлт өгсөн нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2, 50.3, 56 дугаар зүйлийн 56.1 дахь заалттай нийцээгүй байна. Тухайлбал:
  - Буянт сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшсэн 2 нэр дэвшигч Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын дансыг нээлгээгүй, мөн 50.3-т “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу аймаг дахь Төрийн аудитын газарт дансаа бүртгүүлээгүй байна.
- Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон Монгол Ардын намаас нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулсан 2,040.0 мянган төгрөгийн хандивийн орлогыг сонгуулийн дансанд төвлөрүүлэхгүйгээр хувийн хадгаламжийн данснаас, 1,550.0 мянган төгрөгийн өөрийн хөрөнгийг бэлнээр зарцуулжээ.
- Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон Монгол Ардын намаас нэр дэвшсэн нэр дэвшигчд 27 иргэн хандив өргөсөн ба аудитын тайлангаар нийт хандив өргөсөн иргэний 15 хүний регистрийн дугаарыг дутуу тайлагнасныг “Өлгий аудит” ХХК нь баталгаажуулсан байна.

### **Тав. Аудитын дүгнэлт**

1.Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон Буянт сумын Монгол Ардын нам, Ардчилсан намын хорооны болон Монгол Ардын нам, Ардчилсан намаас нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд хувийн аудитын хуулийн этгээдээс үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэсэн дүгнэлт өгсөн байна.

2.Буянт сумын ИТХ-ын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчид сонгуулийн зардлын орлого, зарлагыг бүрэн тайлагнасан байна.

### **Зургаа. Зөвлөмж**

Аудитын дүнгээр зөвлөмж өгөгдөөгүй.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/16

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх заалт, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж нийтэд мэдээлэх аудитын тайланг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг нийтэд мэдээлсүгэй.
3. Аудитын тайланг архивын нэгж болгон баримтжуулж, бичиг хэрэгт хүлээлгэж өгөхийг аудитор (С.Нурлан)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т тус тус даалгасугай.



М.ХУАНГАН